

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| БХБЯ | Барилга, хот байгуулалтын яам |
| ГХБХБГ | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар |
| МҮОНРТ | Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз |
| НҮБ | Нэгдсэн үндэсний байгууллага |
| ТНБД | Төрийн нарийн бичгийн дарга |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар |
| ТӨААТҮГ | Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ТӨХХК | Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани |

Агуулга

| | |
|---|----|
| Агуулга..... | 2 |
| 1. Төрийн аудитын санал, дүгнэлт | 3 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан..... | 5 |
| 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 5 |
| 2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан..... | 6 |
| 2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 8 |
| 2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 9 |
| 2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 10 |
| 2.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан | 11 |
| 3. Аудитын тайлан..... | 12 |
| 3.1. Ерөнхий зүйл..... | 12 |
| 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 12 |
| 3.3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт | 13 |
| 3.4. Материаллаг байдал | 13 |
| 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд | 13 |
| 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт | 14 |
| 3.7. Шилэн дансны мэдээлэл | 15 |
| 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 15 |
| 3.9. Аудитын илрүүлэлт..... | 15 |
| Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил | 15 |
| Аудитын зөвлөмж..... | 15 |
| 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд | 15 |
| 4. Менежментийн захидал..... | 16 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт | 17 |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.МАГНАЙСҮРЭН ТАНАА

2021.02.24 № 07/465
танай _____-ны № _____-т

Аудитын санал, дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын яамны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Барилга, хот байгуулалтын яамны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тус яамны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан "... улсын хэмжээнд байгаа түүх соёлын дурсгалт барилга байгууламжийг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг эхлүүлэх" гэсэн зорилгод ажлыг салбарын төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч тусгай төлөвлөгөө гарган, нарийн мэргэжлийн түвшинд шийдэх ажлын хэрэгжилт хангалтгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 51,367,447.09 | 606,873,209.55 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | 2,373,400.00 |
| 311 | Кассанд байгаа бэлэн мөнгө | - | 2,373,400.00 |
| 31110 | Төгрөг | - | 2,373,400.00 |
| 33 | АВЛАГА | 3,641,950.00 | 543,787,950.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 3,641,950.00 | 543,787,950.00 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 15,137,483.09 | 34,781,064.55 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 15,137,483.09 | 34,781,064.55 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 32,588,014.00 | 25,930,795.00 |
| 354 | Хангамжийн материал | 32,588,014.00 | 25,930,795.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 6,492,325.00 | 3,101,925.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,458,640.00 | 951,240.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 24,637,049.00 | 21,877,630.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 126,198,138.00 | 332,632,755.63 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 126,198,138.00 | 332,632,755.63 |
| 392 | Биет хөрөнгө | 114,325,433.35 | 325,156,298.52 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 376,355,798.00 | 512,955,798.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (376,355,798.00) | (342,224,131.29) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж | 355,994,903.09 | 398,858,717.59 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (300,144,781.34) | (291,814,582.30) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 235,727,069.91 | 234,857,851.07 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (189,469,358.31) | (197,251,434.39) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 17,179,675.00 | 17,179,675.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (4,962,075.00) | (7,405,595.16) |
| 393 | Биет бус хөрөнгө | 11,872,704.65 | 7,476,457.11 |
| 39301 | Програм хангамж | 14,880,810.00 | 1,920,810.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (14,880,810.00) | (1,920,810.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 25,100,800.00 | 25,100,800.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (13,228,095.35) | (17,624,342.89) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 177,565,585.09 | 939,505,965.18 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 177,565,585.09 | 939,505,965.18 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 324,390,884.93 | 324,390,884.93 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 324,390,884.93 | 324,390,884.93 |
| 51101 | Өмч: - төрийн | 324,390,884.93 | 324,390,884.93 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (146,825,299.84) | 615,115,080.25 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (146,825,299.84) | (146,825,299.84) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 761,940,380.09 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 177,565,585.09 | 939,505,965.18 |

2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|------------|---|-------------------------|--------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 7,079,270,107.62 | 10,360,895,596.58 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 27,597,769.04 | 285,539,056.58 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 27,597,769.04 | 285,539,056.58 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 8,514,669.04 | 265,954,056.58 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 8,514,669.04 | 265,954,056.58 |
| 120009 | Бусад орлого | 19,083,100.00 | 19,585,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 7,051,672,338.58 | 10,075,356,540.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 7,031,815,600.00 | 7,881,471,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 7,031,815,600.00 | 7,881,471,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 19,856,738.58 | 2,193,884,740.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 19,856,738.58 | 26,946,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 412,738,740.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 1,754,200,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,240,827,897.49 | 4,591,844,869.60 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,240,827,897.49 | 4,591,844,869.60 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,133,135,934.90 | 4,453,535,636.77 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,149,333,082.00 | 1,867,485,556.71 |
| 210101 | Үндсэн цалин | 1,149,333,082.00 | 1,867,485,556.71 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 145,009,116.82 | 235,003,876.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 100,120,089.79 | 161,753,170.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,778,834.74 | 19,029,786.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,192,668.16 | 14,995,348.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,174,319.47 | 3,565,962.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,743,204.66 | 35,659,610.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 22,445,460.00 | 18,086,010.00 |
| 210304 | Байрны түрээс | 22,445,460.00 | 18,086,010.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 85,602,415.28 | 79,016,345.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 21,675,183.00 | 19,410,058.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,776,393.00 | 16,132,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 14,219,071.28 | 14,118,700.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 19,083,100.00 | 16,085,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,848,668.00 | 13,270,287.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,950,000.00 | 1,232,150.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,950,000.00 | 1,232,150.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 25,121,395.00 | 13,372,900.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 1,313,995.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 23,807,400.00 | 13,372,900.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 501,611,853.71 | 1,741,942,367.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 490,617,893.71 | 1,730,009,835.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 6,820,560.00 | 7,664,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 356,400.00 | 558,552.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,795,000.00 | 3,665,480.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 199,062,612.09 | 497,396,432.06 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,895,500.00 | 426,392,640.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 175,167,112.09 | 71,003,792.06 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 107,691,962.59 | 138,309,232.83 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 102,197,663.00 | 86,770,652.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 45,034,715.00 | 23,605,249.00 |

Барилга, хот байгуулалтын яамны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|------------|---|--------------------------------|--------------------------------|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 57,162,948.00 | 63,165,403.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 5,494,299.59 | 51,538,580.83 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,494,299.59 | 51,538,580.83 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН | <u>4,838,442,210.13</u> | <u>5,769,050,726.98</u> |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 5,616,820,533.05 | 5,007,110,346.89 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 616,820,533.05 | 7,110,346.89 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 5,000,000,000.00 | 5,000,000,000.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН | -5,616,820,533.05 | -5,007,110,346.89 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН | <u>-778,378,322.92</u> | <u>761,940,380.09</u> |

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|------------|---|--------------------------------|---------------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | <u>7,070,755,438.58</u> | <u>10,100,956,890.00</u> |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 19,083,100.00 | 21,958,400.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 19,083,100.00 | 21,958,400.00 |
| 120009 | Бусад орлого | 19,083,100.00 | 21,958,400.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 7,051,672,338.58 | 10,078,998,490.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 7,031,815,600.00 | 7,881,471,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 7,031,815,600.00 | 7,881,471,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 19,856,738.58 | 2,197,526,690.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 19,856,738.58 | 26,946,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 412,738,740.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 1,754,200,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | <u>2,056,813,838.58</u> | <u>5,079,988,790.00</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,056,813,838.58 | 5,079,988,790.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,962,432,023.99 | 4,397,891,607.17 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,160,604,300.00 | 1,855,577,514.17 |
| 210101 | Үндсэн цалин | 707,056,600.00 | 1,453,437,914.17 |
| 210102 | Нэмэгдэл | 402,129,500.00 | 350,721,400.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 51,418,200.00 | 51,418,200.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 145,075,600.00 | 266,513,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 98,651,400.00 | 187,546,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,606,100.00 | 19,741,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,284,800.00 | 15,793,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,321,200.00 | 3,948,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23,212,100.00 | 39,483,500.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 18,209,510.00 | 18,086,010.00 |
| 210304 | Байрны түрээс | 18,209,510.00 | 18,086,010.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 83,072,217.28 | 73,588,746.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 18,669,633.00 | 15,762,528.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,776,393.00 | 16,132,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 14,219,071.28 | 14,118,700.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 19,083,100.00 | 16,085,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 13,324,020.00 | 11,490,218.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,950,000.00 | 1,232,150.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,950,000.00 | 1,232,150.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 25,121,395.00 | 13,372,900.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 1,313,995.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 23,807,400.00 | 13,372,900.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 499,182,761.71 | 1,743,128,147.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 487,033,801.71 | 1,731,195,595.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 6,820,560.00 | 7,664,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 356,400.00 | 558,552.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,950,000.00 | 3,665,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,216,240.00 | 426,392,640.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,216,240.00 | 426,392,640.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 94,381,814.59 | 682,097,182.83 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 88,887,515.00 | 86,770,652.00 |

| | | | |
|----------|--|----------------------------------|----------------------------------|
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 36,134,715.00 | 23,605,249.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 52,752,800.00 | 63,165,403.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 5,494,299.59 | 595,326,530.83 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,494,299.59 | 51,538,580.83 |
| 213305 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 543,787,950.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | <u>5,013,941,600.00</u> | <u>5,020,968,100.00</u> |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 13,941,600.00 | 18,594,700.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 13,941,600.00 | 18,594,700.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 13,941,600.00 | 18,594,700.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 13,941,600.00 | 18,594,700.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | <u>(13,941,600.00)</u> | <u>(18,594,700.00)</u> |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 5,000,000,000.00 | 5,000,000,000.00 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 5,000,000,000.00 | 5,000,000,000.00 |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | <u>(5,000,000,000.00)</u> | <u>(5,000,000,000.00)</u> |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | 2,373,400.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 2,373,400.00 |

2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|--|---------------------------------|-----------------------|-------------------------|--|
| 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 324,390,884.93 | - | 631,553,023.08 | 955,943,908.01 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 324,390,884.93 | - | 631,553,023.08 | 955,943,908.01 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (778,378,322.92) | (778,378,322.92) |
| 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 324,390,884.93 | - | (146,825,299.84) | 177,565,585.09 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 324,390,884.93 | - | (146,825,299.84) | 177,565,585.09 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 761,940,380.09 | 761,940,380.09 |
| 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 324,390,884.93 | - | 615,115,080.25 | 939,505,965.18 |

2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--|--------------------------|-------------------------|-------------------------|-------|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 11,981,471,800.00 | 7,829,933,219.17 | 4,151,538,580.83 | 65.4 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 6,981,471,800.00 | 2,829,933,219.17 | 4,151,538,580.83 | 40.5 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,794,281,300.00 | 2,743,162,567.17 | 51,118,732.83 | 98.2 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,901,856,700.00 | 1,855,577,514.17 | 46,279,185.83 | 97.6 |
| Үндсэн цалин | 1,499,717,100.00 | 1,453,437,914.17 | 46,279,185.83 | 96.9 |
| Нэмэгдэл | 350,721,400.00 | 350,721,400.00 | - | 100.0 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 51,418,200.00 | 51,418,200.00 | - | 100.0 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 266,513,500.00 | 266,513,500.00 | - | 100.0 |
| Тэтгэврийн даатгал | 187,546,600.00 | 187,546,600.00 | - | 100.0 |
| Тэтгэмжийн даатгал | 19,741,700.00 | 19,741,700.00 | - | 100.0 |
| ҮОМШӨ-ний даатгал | 15,793,400.00 | 15,793,400.00 | - | 100.0 |
| Ажилгүйдлийн даатгал | 3,948,300.00 | 3,948,300.00 | - | 100.0 |
| Эрүүл мэндийн даатгал | 39,483,500.00 | 39,483,500.00 | - | 100.0 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 18,210,000.00 | 18,086,010.00 | 123,990.00 | 99.3 |
| Байрны түрээс | 18,210,000.00 | 18,086,010.00 | 123,990.00 | 99.3 |
| Хангамж, бараа материалын зардал | 59,437,300.00 | 57,503,646.00 | 1,933,654.00 | 96.7 |
| Бичиг хэрэг | 17,096,600.00 | 15,762,528.00 | 1,334,072.00 | 92.2 |
| Тээвэр, шатахуун | 16,132,200.00 | 16,132,200.00 | - | 100.0 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 14,118,700.00 | 14,118,700.00 | - | 100.0 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,089,800.00 | 11,490,218.00 | 599,582.00 | 95.0 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 1,232,200.00 | 1,232,150.00 | 50.00 | 100.0 |
| Урсгал засвар | 1,232,200.00 | 1,232,150.00 | 50.00 | 100.0 |
| Томилолт, зочны зардал | 13,372,900.00 | 13,372,900.00 | - | 100.0 |
| Дотоод албан томилолт | 13,372,900.00 | 13,372,900.00 | - | 100.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 517,604,600.00 | 517,222,947.00 | 381,653.00 | 99.9 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 505,459,200.00 | 505,290,395.00 | 168,805.00 | 100.0 |
| Даатгалын үйлчилгээ | 7,664,500.00 | 7,664,500.00 | - | 100.0 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 712,800.00 | 558,552.00 | 154,248.00 | 78.4 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 99,000.00 | 44,000.00 | 55,000.00 | 44.4 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,669,100.00 | 3,665,500.00 | 3,600.00 | 99.9 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 16,054,100.00 | 13,653,900.00 | 2,400,200.00 | 85.0 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 16,054,100.00 | 13,653,900.00 | 2,400,200.00 | 85.0 |
| ТАТААС | 4,100,000,000.00 | - | 4,100,000,000.00 | - |
| Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 4,100,000,000.00 | - | 4,100,000,000.00 | - |
| Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 4,100,000,000.00 | - | 4,100,000,000.00 | - |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 87,190,500.00 | 86,770,652.00 | 419,848.00 | 99.5 |
| Бусад урсгал шилжүүлэг | 87,190,500.00 | 86,770,652.00 | 419,848.00 | 99.5 |
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 24,019,500.00 | 23,605,249.00 | 414,251.00 | 98.3 |

| | | | | |
|---|-------------------------|-------------------------|----------------------|-------------|
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 63,171,000.00 | 63,165,403.00 | 5,597.00 | 100.0 |
| ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 5,000,000,000.00 | 5,000,000,000.00 | - | 100.0 |
| Эргэж төлөгдөх зээл | 5,000,000,000.00 | 5,000,000,000.00 | - | 100.0 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 7,881,471,800.00 | 7,829,933,219.17 | 51,538,580.38 | 99.3 |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 7,881,471,800.00 | 7,829,933,219.17 | 51,538,580.38 | 99.3 |
| Улсын төсвөөс санхүүжих | 7,881,471,800.00 | 7,829,933,219.17 | 51,538,580.38 | 99.3 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | - | |
| Ажиллагсад бүгд | 78 | 73 | 5 | 93.6 |
| Удирдах ажилтан | 13 | 13 | - | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 58 | 53 | 5 | 91.4 |
| Үйлчлэх ажилтан | 7 | 7 | - | 100.0 |

2.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|------------|-------------------------|
| Мөнгөн хөрөнгийн 2020 оны 1-р сарын 1-ны үлдэгдэл | | - |
| ОРЛОГЫН ДҮН | | 2,197,526,690.00 |
| Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 2,197,526,690.00 |
| Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 30,587,950.00 |
| ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 412,738,740.00 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 1,754,200,000.00 |
| А.УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | | 1,653,738,740.00 |
| Бараа үйлчилгээний зардал | | 1,653,738,740.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | | 1,241,000,000.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | | 412,738,740.00 |
| Татаас ба урсгал шилжүүлэг | | 543,787,950.00 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | | 543,787,950.00 |
| Мөнгөн хөрөнгийн 2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл | | - |

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Барилга, хот байгуулалтын яамны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд автомашиныг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэх эсэх асуудлыг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулахгүй байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэзул, аудитор О.Баярмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Барилга, хот байгуулалтын яам нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 3/281 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Барилга, хот байгуулалтын яамны эрхэм зорилго нь хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүй, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын үр нөлөөг дээшлүүлэх замаар хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны стратегийн зорилтуудыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүй, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын хууль тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, салбарын норм, нормативын баримт бичгийн тогтолцоог бүрдүүлэх, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх;
- Тус яамны чиг үүрэгтэй холбогдон гарсан хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт, шалгалт, хяналт-шинжилгээ, аудит хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах;
- Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, санхүү, эдийн засгийн төлөвлөлтийн үр дүнг дээшлүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Барилга, барилгын материалын үйлдвэрлэл, нийтийн аж ахуй, орон сууцны, инженерийн дэд бүтцийн, хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүйн салбаруудын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;

3.3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд Барилга, хот байгуулалтын яамны аппаратын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газраас 2020 оны шилэн дансанд улирал тутамд хийсэн дотоод аудитаар нийт 19 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн байна.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 9,598,955.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 95,989.5 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Барилга, хот байгуулалтын яамны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 761.940.4 мянган төгрөгөөр буюу 429.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|------------------|------------------|------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 2,373.4 | 2,373.4 |
| Авлага | 3,642.0 | 543,788.0 | 540,146.0 |
| Урьдчилгаа | 15,137.5 | 34,781.1 | 19,643.6 |
| Бараа материал | 32,588.0 | 25,930.8 | (6,657.2) |
| Үндсэн хөрөнгө | 126,198.1 | 332,632.8 | 206,434.6 |
| Нийт хөрөнгийн дүн | 177,565.6 | 939,506.0 | 761,940.4 |
| Засгийн газрын хувь оролцоо | 177,565.6 | 939,506.0 | 761,940.4 |
| Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн | 177,565.6 | 939,506.0 | 761,940.4 |

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 206,434.6 мянган төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын даргын 2020 оны А-1/721, А-1/1106, А-1/1455, А-1/2230 дугаар албан бичгээр тус яамны харьяа Ногоон нуур 1008 айлын орон сууц төслийн нэгж, “Улаанбаатар хотын 7,14, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц төслийн нэгж, Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-аас нийт 265,954.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 540,146.0 мянган төгрөгөөр өссөн нь Ногоон нуур 1008 айлын орон сууц төслийн газар чөлөөлөлтийн төлбөрт олгогдоогүй үлдэгдлийг оны эцэст улсын төсөвт төвлөрүүлэн авлага үүсгэж бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 939,506.0 мянган төгрөг болж 761,940.4 мянган төгрөгөөр өссөн нь тус яамны харьяа Ногоон нуур 1008 айлын орон сууц төслийн нэгж, УБ хотын 7,14, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц төслийн нэгж, Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-аас үндсэн хөрөнгө шилжүүлэн авсан, мөн Ногоон нуур 1008 айлын орон сууц төслийн газар чөлөөлөлтийн төлбөрийг бүрэн олгоогүй зэргээс шалтгаалжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагчийн 2020 оны үйл ажиллагаанд 2,829,933.2 мянга, Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх зарим хөтөлбөрийн хүрээнд Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-д олгох дамжуулан зээлдүүлэх зээлийн эх үүсвэрт 5,000,000.0 мянга, төрийн өмчит байгууллагад олгох татааст 4,100,000.0 мянга, нийт 11,981,471.8 мянган төгрөгийн төсөв төлөвлөж хүргүүлснийг хэвээр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,829,933.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос урсгал үйл ажиллагаанд 2,778,394.6 мянган төгрөгийг зарцуулж, 51,538.6 мянган төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-д олгох 5,000,000.0 мянган төгрөгийг дамжуулан зээлдүүлэх зээлийн төлбөрт шилжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 98.2 хувьтай байгаа нь тайлант онд батлагдсан орон тоонд 7 ажилтан нөхөж аваагүйгээс цалин хөлсний зардлыг 46,279.2 мянган төгрөгөөр, бусад зардлыг 5,259.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна. Мөн Харгиа цэвэрлэх байгууламжийг Улаанбаатар хотоос гаргахаар хэлэлцэж байгаатай холбоотой төрийн өмчит байгууллагад олгох 4,100,000.0 мянган төгрөгийн татаасыг олгоогүй байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зарим хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж Засгийн газрын нөөц сангаас ГХБХБГ-ын 150,000.0 мянга, Аэросити төслийн 180,000.0 мянга, Майдар хот төслийн 82,738.7 мянга, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс Ногоон нуур 1008 айлын орон сууц төслийн газар чөлөөлөлтийн төлбөрт 1,754,200.0 мянга, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн төслөөс 30,587.9 мянга, нийт 2,197,526.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Аэросити төслийн 180,000.0 мянга, ГХБХБГ-ын 150,000.0 мянга, Майдар хот төслийн 82,738.7 мянган төгрөгийг тус тус зарцуулж, Ногоон нуур 1008 айлын орон сууц төслийн газар чөлөөлөлтийн төлбөрт 1,241,000.0 мянган төгрөгийг зарцуулж, олгогдоогүй

үлдэгдэл 513,200.0 мянган төгрөг, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн төслийн зарцуулагдаагүй үлдэгдэл 30,587.9 мянган төгрөг, нийт 543,787.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 89 мэдээллээс 55 мэдээллийг хугацаандаа оруулж, 34 мэдээллийг байршуулаагүй байсныг аудитын явцад нөхөж оруулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчлийг арилгах 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 55,215.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 48,765.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 6,450.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 48,765.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

Тайлант онд төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн урамшуулал олгохдоо холбогдох журамд заасан хувиас хэтрүүлэн нийт 48,765.8 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна" гэж заасантай нийцэхгүй, мөн “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах;

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 6,450.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал гараагүй.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөө ашиглалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тус яамны үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй нийт 5 автомашины 4ш нь ашиглалтын хугацаа дуусч үлдэх өртөггүй болсон ба автомашиныг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 3.7-д "... автомашин шинээр худалдан авах санал ирүүлэхдээ илүүдэлтэй эсхүл ашиглалтын шаардлага хангахгүй автомашиныг худалдах, шилжүүлэх, актлах асуудлыг хамтад тавьж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Ашиглагдахгүй байгаа хөрөнгийг холбогдох эрх бүхий байгууллагад саналаа хүргүүлж шийдвэрлүүлээгүйгээс хөрөнгө ашиглалтгүй эзэнгүйдэх,

1.3. Өгсөн зөвлөмж:

Автомашиныг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авах,

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлээр баталгаажуулсан.

2. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

БХБЯ-ны албан хаагчдын "Их барилга-94" нэгдсэн арга хэмжээнд зориулж 6,450.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг мөрдөөгүй байна.

2.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, холбогдох хуулийн заалт зөрчигдөх;

2.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг мөрдөх,

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлээр баталгаажуулсан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|------------------------------|-------------------------------|--|---------------------|
| Огноо: | Аудитын нэр: | <i>Барилга, хот байгуулалтын яамны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i> | Аудитын код: |
| 2020 | | | САГ-2021/15/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Барилга, хот байгуулалтын яам | | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|--|-----------------|---------------------------------------|---|---------------------------|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Тайлант онд төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн урамшуулал олгохдоо холбогдох журамд заасан хувиас хэтрүүлэн нийт 48,765.8 мянган төгрөгийг илүү олгосон, | 48,765.8 | Албан шаардлага өгсөн | ТНБД, Ахлах нягтлан бодогч | С.Магнайсүрэн П.Дэлгэрмаа |
| 2 | Тус яамны үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй нийт 5 автомашины 4ш нь ашиглалтын хугацаа дуусч үлдэх өртөггүй болсон ба автомашиныг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй, | - | Зөвлөмж өгсөн | ТНБД, Ахлах нягтлан бодогч | С.Магнайсүрэн П.Дэлгэрмаа |
| 3 | "Их барилга-94" БХБЯ-ны албан хаагчдын нэгдсэн арга хэмжээнд зориулж 6,450.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. | 6,450.0 | Зөвлөмж өгсөн | ТНБД, Ахлах нягтлан бодогч | С.Магнайсүрэн П.Дэлгэрмаа |
| | Дүн | 55,215.8 | | | |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 24

№ 03/АД/170066

Улаанбаатар хот

САГ-2021/15/СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Барилга, хот байгуулалтын яамны аппаратын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн урамшуулал олгохдоо холбогдох журамд заасан хувиас хэтрүүлэн 81 ажилтанд нийт 48,765.8 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", мөн Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цаашид батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, мөн холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах;
2. Албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор гаргаж Үндэсний Аудитын газарт ирүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, ахлах нягтлан бодогч П.Дэлгэрмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

О.БАЯРМАА

